



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/014/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор С.Намшир

Утас: 70272287 Цахим хаяг: [namshirs@audit.gov.mn](mailto:namshirs@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025. 03. 24 № 01/270  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Ц.ЭНХБОЛД ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төв аймгийн Угтаалцайдам сум нь орон нутагт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 501,951.0 мянган төгрөгөөр давуулан, 187,7 хувиар биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хогны автомашин 48,800.0 мянган төгрөг, ЗДТГ-ын дээврийн их засварын ажил 50,000.0 мянган төгрөг, сургуулийн спорт заалны зураг төсөв хийх үйлчилгээ 50,000.0 мянган төгрөг, Хар чулуут багийн төвийн засварын ажил 10,000.0 мянган төгрөг, малын үүлдэр угсааг сайжруулахаар Сэлэнгэ үүлдрийн бух 14,000.0 мянган төгрөг, Ковш-30 трактор худалдан авахад 118,500.0 мянган төгрөг, багуудад худаг шинээр гаргах ажил 72,000.0 мянган төгрөг, худаг засварын ажил 5,000.0 мянган төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Угтаалцайдам сумын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг 31 зорилт, 89 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлснийг сумын ИТХ-ын тогтоолоор 94,0 хувиар дүгнэж, хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 4 зорилт, 85 арга хэмжээтэй хэрэгжилт 79,4 хувьтай, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 5 зорилт, 37 хэрэгжүүлэх арга хэмжээтэй 90,0

4126020664

хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,088,164.88</b>	<b>1,369,540.75</b>
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	675,946.47	897,284.77
1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	298,025.63	343,123.94
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	114,192.78	129,132.04
<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,267,447.17</b>	<b>2,431,327.52</b>
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,267,447.17	2,431,327.52
1.2.2.02 Биет хөрөнгө		2,125,358.54	2,281,019.73
1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	142,088.63	150,307.79
<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>3,355,612.05</b>	<b>3,800,868.27</b>
<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>20,547.28</b>	<b>52,715.75</b>
<b>2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>20,547.28</b>	<b>52,715.75</b>
2.1.1.03 Өглөг		20,547.28	52,715.75
<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,335,064.77</b>	<b>3,748,152.52</b>
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,335,064.77	3,748,152.52
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		583,063.39	583,063.39
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,555,810.1	2,968,897.85
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		196,191.27	196,191.27
<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>3,355,612.05</b>	<b>3,800,868.27</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>3,395,316.84</b>	<b>3,260,083.97</b>
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		662,583.3	1,046,269.1
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,044,481.79	2,213,814.87
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,688,251.75	0.0
<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>2,392,450.6</b>	<b>2,845,736.22</b>
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,937,103.33	2,409,772.75

<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,819,910.96</b>	<b>2,351,994.21</b>
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		680,210.56	862,222.91
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		81,575.26	106,774.32
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		613,627.14	631,804.25
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		59,040.16	54,133.98
1.1.2.01.1.05 Нормативд зардал		132,882.02	117,108.59
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		43,799.1	58,119.24
1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		9,250	6,538.1
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		22,007.87	11,333.94
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		177,518.84	503,958.88
<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>117,192.37</b>	<b>57,778.54</b>
<b>1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>455,347.27</b>	<b>435,963.47</b>
<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>1,002,866.24</b>	<b>414,347.75</b>
<b>1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>118,906.55</b>	<b>1,260</b>
<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>		<b>-118,906.55</b>	<b>-1,260</b>
<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>		<b>883,959.68</b>	<b>413,087.75</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

<b>Дансны нэр, төрөл</b>	<b>Засгийн газрын хувь оролцооны нийт дүн</b>	<b>Нийт цэвэр хөрөнгө /өмч</b>
<b>1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,451,105.08</b>	<b>2,451,105.08</b>
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,286.8	9,286.8
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,460,391.88	2,460,391.88
1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-9,286.8	-9,286.8
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	883,959.68	883,959.68
<b>1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,335,064.77</b>	<b>3,335,064.77</b>
<b>1.1.1 2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>3,335,064.77</b>	<b>3,335,064.77</b>

1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,335,064.77	3,335,064.77
1.7 Тайлант үеийн үр дүн	413,087.75	413,087.75
<b>1 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,748,152.52</b>	<b>3,748,152.52</b>

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,521,061.73</b>	<b>2,773,593.08</b>
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	662,583.30	1,046,269.10
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	170,226.68	1,727,323.98
1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,688,251.75	0.0
<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,770,350.70</b>	<b>1,988,273.26</b>
<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,770,350.70</b>	<b>1,988,273.26</b>
<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,653,158.32</b>	<b>1,930,031.12</b>
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	672,531.48	875,992.91
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,441.04	109,254.82
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	613,627.14	631,804.25
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	38,971.93	38,710.78
1.1.1.2.01.1.05 Нормативд зардал	133,116.70	124,139.39
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	41,618.50	78,915.10
1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	9,250.00	5,978.10
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,135.34	31,350.37
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	51,466.19	33,885.41
<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,192.37</b>	<b>58,242.14</b>
<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>750,711.03</b>	<b>785,319.82</b>
<b>1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>627,516.24</b>	<b>513,831.52</b>
<b>1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>627,516.24</b>	<b>513,831.52</b>
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	627,516.24	513,831.52
<b>1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-627,516.24</b>	<b>-513,831.52</b>
<b>1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>150.00</b>	<b>50,150.00</b>

<b>1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-150.00</b>	<b>-50,150.00</b>
<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>123,044.79</b>	<b>221,338.30</b>
1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	552,901.67	675,946.47
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	675,946.47	897,284.77

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,835,547.70</b>	<b>4,151,032.13</b>	<b>(315,484.43)</b>	<b>108.2</b>
11	Татварын орлого	565,667.50	1,046,269.10	(480,601.60)	185.0
12	Татварын бус орлого	3,269,880.20	3,104,763.04	165,117.16	95.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,623,227.40</b>	<b>4,240,767.40</b>	<b>382,460.00</b>	<b>91.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,831,227.40</b>	<b>3,771,491.49</b>	<b>59,735.90</b>	<b>98.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,876,580.00</b>	<b>1,798,751.59</b>	<b>77,828.41</b>	<b>95.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	800,517.30	787,708.16	12,809.14	98.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,366.00	98,207.85	2,158.15	97.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	638,536.10	631,804.25	6,731.85	98.9
2104	Хангамж, бараа материалын зардал	47,708.80	35,206.60	12,502.20	73.8
2105	Нормативд зардал	1,190.00	1,190.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	149,408.30	142,513.96	6,894.34	95.4
2107	Томилолт, зочны зардал	10,206.00	5,978.10	4,227.90	58.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,597.50	36,321.87	27,275.63	57.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,050.00	59,820.81	5,229.19	92.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,039.60</b>	<b>57,132.14</b>	<b>17,907.46</b>	<b>76.1</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,039.60	57,132.14	17,907.46	76.1
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>656,000.00</b>	<b>419,125.91</b>	<b>236,874.09</b>	<b>63.9</b>

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	100,000.00	50,150.00	49,850.00	50.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	645,082.42	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	864,154.12	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	265,333.20	103,945.90
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	265,333.20	103,945.90
122	Тусламжийн орлого	265,333.20	103,945.90
1221	Хандив тусламж /дотоод/	265,333.20	103,945.90
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	265,333.20	103,945.90
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	265,333.20	103,945.90
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	265,333.20	103,945.90
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	239,660.10	102,835.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,559.40	88,284.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,299.60	11,046.97
2104	Хангамж, бараа материалын зардал	5,186.10	3,504.18
2107	Томилолт, зочны зардал	680.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,270.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,665.00	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,673.10	1,110.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,673.10	1,110.00

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг дарга	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					

3	Засаг даргын тамгын газар	1	1				1		
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1		1					
<b>Нийт</b>		<b>7</b>	<b>2</b>	<b>5</b>			<b>1</b>	<b>1</b>	

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	30,564.8			1	30,564.8	1	30,564.8
ЭЭС	1	109,153			1	109,153	1	109,153
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>139,717.7</b>	<b>0</b>		<b>2</b>	<b>139,717.7</b>	<b>2</b>	<b>139,717.7</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	32,514.6			2	32,514.6		
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	2,733.5	1	931.0			2	1,802.5
Засаг даргын тамгын газар	7	61,055.7	2	4,046.9	3	18,458.8	2	38,550.0
Хоршоо хөгжүүлэх сан	2	158,807.2			1	121,688.3	1	37,118.9
Эмийн эргэлтийн сан	2	49,129.3	1	49,129.3			1	-
<b>Дүн</b>	<b>16</b>	<b>304,240.3</b>	<b>4</b>	<b>54,107</b>	<b>6</b>	<b>172,662</b>	<b>6</b>	<b>77,471</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Засаг дарга	1	-			1	-				
ЗДТГ	1	-			1	-				
ИТХ	1	-			1	-				
ЭЭС	1	-			1	-				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>-</b>			<b>4</b>	<b>-</b>				

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)